



**Friends of Mongolia's and the Allentown West Rotary Club's Mongolia 21|21 Scholarship Program 2023-2024 is announced for Khovd Province.**

Friends of Mongolia, in partnership with the Allentown West Rotary Club in Pennsylvania, announces a scholarship program to support a student with social activeness and high academic potential who wants to attend university in Mongolia.



Scholarship applications will be accepted from July 1-31, 2023. Early submissions will not be accepted.

**Requirements:**

- must be from Khovd Province
- must be a freshman in a domestic university in the upcoming school year
- must have an average at/above 90% in school
- demonstrates a need for tuition support
- demonstrates leadership potential
- not participating in scholarships and allowances from other sources

**Required documents:**

- The application form should be filled. While filling out the form the below personal statements should be provided:
  - Your achievements, received prizes, and social activeness in the last three years.
  - An essay on your goals, future plans and reasons for choosing your major.
  - Why we must select you.
  - An essay on how you can help us build goodwill and better friendships between Mongolians and Americans.
- The following supporting documents should be enclosed to your application:
  - Documents to certify your achievement /academic, volunteering, sports and international competitions/ in the last three years.
  - Secondary school certificate
  - Residency reference
  - Identity card

**Additional information:**

Please note that only the first 50 scholarship applications will be accepted, and subsequent submissions will not be considered for the scholarship selection process. The link for submissions will be shared on July 1<sup>st</sup>. *We will keep your personal information confidential and will not share it with others for any purpose.*

Please send scholarship-related questions to [scholarships@friendsofmongolia.org](mailto:scholarships@friendsofmongolia.org).



**МОНГОЛЫН АНДУУД ТББ, АЛЛЕНТАУН ВЕСТ  
РОТАРИ КЛУБ  
МОНГОЛ 21|21 ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2023-2024,  
ХОВД АЙМАГ**



Монголын Андууд ТББ, АНУ-ын Пеннсилвани мужийн Аллентаун Вест Ротари Клубтэй хамтран нийгмийн идэвхтэй, сурлагын өндөр амжилт гаргасан сурагчдад Монголын их, дээд сургуульд элсэн суралцахад дэмжлэг үзүүлэх сургалтын тэтгэлэгт хөтөлбөр зарлаж байна.

Уг тэтгэлэгт хөтөлбөрийн өргөдлийн маягтыг 2023 оны 7-р сарын 1-нээс 31-ны хооронд хүлээн авна. Үүнээс өмнө өргөдлийг хүлээн авах боломжгүй.

**Тавигдах шаардлага:**

- Ховд аймгийн харьяалалтай байх
- 2023-2024 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургуульд 1-р курст элсэн суралцагч байх
- Сурлагын дүн сайтай байх /90%-с дээш/
- Сургалтын төлбөрийн дэмжлэг шаардлагатай байх
- Нийгмийн үйл ажиллагаанд манлайлан оролцдог/оролцох хүсэлтэй байх
- Бусад эх үүсвэрээс тэтгэлэг, тэтгэмжид хамрагдаагүй байх

**Бүрдүүлэх материал:**

- Өргөдлийн маягтыг бүрэн гүйцэд бөглөсөн байна. Холбогдох мэдээллийг бөглөхийн хажуугаар дараах асуултуудын дагуу бичнэ. Үүнд:
  - Сүүлийн 3 жилд хугацаанд гаргасан амжилт, шагнал урамшуулал, нийгмийн идэвхийн талаар бичнэ
  - Өөрийн ирээдүйн зорилго, төлөвлөгөө болон мэргэжлээ сонгосон шалтгааны талаар эссэ бичнэ
  - Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ бичнэ. Бид яагаад танд тэтгэлэг өгөх ёстой вэ?
  - Монгол, Америк улсын хооронд нөхөрсөг харилцааг бэхжүүлэхэд таны зүгээс ямар хувь нэмэр оруулах боломжтой талаар эссэ бичнэ.
- Дараах материалыг хавсаргана. Үүнд:
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд сурлагын болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд (сайн дурын ажил, спорт, олон улсын тэмцээн уралдаан) амжилт гаргасныг гэрчлэх баримт бичиг
  - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ
  - Оршин суугаа газрын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэхийн хуулбар

**Нэмэлт мэдээлэл:**

Энэхүү хөтөлбөрт эхний 50 тэтгэлгийн хүсэлтийг хүлээн авах ба үүнээс хойших материалыг тэтгэлгийн шалгаруулалтад оролцуулахгүй болохыг анхаарна уу. 2023 оны 7-р сарын 1-нд өргөдлийн маягт руу орох холбоосыг нээлттэй болгоно. Бид таны хувийн мэдээллийг чандлан хадгалах бөгөөд ямар нэгэн зорилгоор бусдад хуваалцахгүй.

Тэтгэлэгтэй холбоотой асуулт байвал [scholarships@friendsofmongolia.org](mailto:scholarships@friendsofmongolia.org) руу илгээнэ үү.